# СОЁЛ



**01**
Соёлын тухай ойлголт

**02**
Соёлын нэгдэл ба олон янз байдал

**03**
СОЁЛЫГ ХЭРХЭН АНГИЛЖ БОЛОХ ВЭ?

**04**
ХУВЬ ХҮН СОЁЛЫН ТӨЛӨӨЛӨЛ БОЛОХ НЬ

**05**
СОЁЛЫН ЭРХ ЧӨЛӨӨ



# СОЁЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ













Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар дадлуудыг багтаасан цогц бүхэллэг зүйл юм.

*(Эдуард Тайлор)*

**Антропологийн хандлага**

- Янз бүрийн ард түмний домог, аман зохиол зэрэг соёлын уламжлалыг харьцуулан судлах замаар тэдгээрт буй адил төстэй нийтлэг шинж байдлыг тайлбарлахыг хичээдэг.

**Философийн хандлага**

- Соёлыг хүний мөн чанарын илэрхийлэл мөн болох талаас нь тайлбарладаг. Соёлын утга санаа нь хүний гэх зүйлийг ялгах хязгаар болж өгдөг гэдгийг энэ хандлагад онцлон үздэг.

**Социологийн хандлага**

- Соёлыг аливаа нийгмийн аж төрөх ёс, нийгмийн зохион байгуулалтын бүрдүүлэгч хүчин зүйл гэдэг талаас нь тайлбарладаг. Соёл бол өв уламжлан авсан бүтээл, юмс техникийн үйл ажиллагаа , үзэл санаа, зан үйл, үнэт зүйлс мөн гэх мэт (Малиновский)




О. Шпенглер дэлхийн нэг нэгдмэл соёл байх боломжгүй, харин өөр өөрийн хувь тавилан бүхий янз бүрийн соёл байна гэжээ. Хүмүүс соёлын үнэт зүйлийг бүтээхийн төлөө бус, харин олз ашиг олох эрмэлзэл, амьдралаа төвхнүүлэх явдлаар хөөцөлдөж эхэлснээр хүний амьдралд соёлын гүйцэтгэх утга санаа алдагдаж эхэлнэ. Түүнийхээр соёл нь хүний сэтгэлтэй гүн бат, ойр холбоотой байж л амьд байна.

Та юу гэж бодож байна.





# №2 СОЁЛЫН НЭГДЭЛ БА ОЛОН ЯНЗ БАЙДАЛ








Соёлын зөрчилдагч хэсгүүдийг нэгтгэж, нийцтэй, нягтралтай бүхлийг бүтээхийг соёлын нэгдэл гэнэ.




Соёл бүр өөрийн онцлогтой ч нийтлэг талуудтай байдаг.



# СОЁЛЫН НЭГДЭЛ БА ОЛОН ЯНК БАЙДАЛ

- Соёлын нийтлэг талууд нь хүн төрөлхтний соёл нэгдэлтэй болохыг харуулдаг.

- Тухайн нийгмийн соёлын бүрэлдэх хэсгүүдийн дотоод нэгдэл, бас зөрчлийн тухай ярьж болно.







ЭТНОЦЕНТРИЗМ (ҮНДЭСТЭН ТӨВТ ҮЗЭЛ)

Өөрийнхөө соёлыг бусдынхаас дээгүүр гэж үзэж, өөр соёлын лотор өссөн хүмүүсийн зан байдал, итгэл үнэмшлийг өөрийн соёлын үүднээс үнэлэх хандлага

СОЁЛЫН РЕЛЯТИВИЗМ (СОЁЛЫН ХАРЬЦАНГУЙ ҮЗЭЛ)

Энэ үзэл өөр өөр нийгмийн орчин нь өөр хэм хэмжээ, үнэлэмжийг төрүүлдэг тиймээс бусад соёлыг “хачин”, “сонин” гэж үл тоомсорлохоос илүү ойлгох ёстой гэж үздэг үзэл хандлага







# 2.3 Соёлыг хэрхэн ангилж болох вэ?

## СОЁЛЫН ТҮВШИН

- ОЛОН УЛСЫН
  - ДАЯАРШИЛ
  - НҮБ
- УЛС ҮНДЭСНИЙ
  - БУДДЫН СОЁЛ
  - НҮҮДЛИЙН ИРГЭШИЛ






## ДЭД СОЁЛ

Аливаа улс үндэсний соёл нь нэгэн жигд байдаггүй, үндэс угсаа, ажил мэргэжлийн хот хөдөөгийн гэх мэт соёлын олон янзын үнэт зүйлс уламжлал бүхий дэд бүлгүүдээс тогтдог.

Дэд соёл гэдэг нэр томьёо аль нэг бүлгийн соёл нийгэмд зонхилж буй соёлын эсрэг байдаг гэсэн утгатай нэр томьёо биш.

Дэд соёлуудаас хамгийн тогтвортой нь угсаатны бүлгүүийн соёл байдаг.

**Нийгмийг бүрдүүлэгч бүлгүүдийг ялгаж байгаа хэм хэмжээ, үнэт зүйлийн системийг дэд соёл гэнэ.**

# Биет ба биет бус соёл

**Соёлыг хүний үйл ажиллагааны үр дүн гэдэг утгаар нь биет ба биет бус гэсэн 2 хэлбэртэй гэж үздэг.**

# Үндэсний соёл, урлагийг хэн бүтээж байна, ямар түвшний соёл байна гэдгээс хамааруулаад дараах байдлаар ангилдаг

| Ардын соёл | Сонгодог соёл | Нийтийн соёл |
| --- | --- | --- |
| Морин хуур, уртын дуу зөвхөн монгол туургатанд байдаг. Ардын соёлыг ардын билиг авьяастнууд бүтээдэг. | Сонгодог соёлыг нийгмийн элит хэсэг юмуу, түүний захиалгаар мэргэжлийн уран бүтээлчид бүтээдэг. | XX зууны дунд үе Радио , телевиз Уран сайхны үнэ цэнэ багатай хамгийн олон үзэгчтэй |

# 2.4. Хувь хүн соёлын төлөөлөл болох нь






**Хувь хүний соёлын түвшин гэдэг нь түүхэн хөгжлийн онцлогоор биш, харин тухайн хүний дотоод ертөнц, үнэлэм жийн хөгжил, төлөвшлийн ялгаа юм.**

# Хувь хүний хэрэгцээ

1 Материаллаг хэрэгцээ

2 Өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ

3 Бүтээн туурвих хэрэгцээ

“

**Мэргэн ухааны гол зорилго нь сайн, мууг ялгахад оршино.**

”

**Сократ**



# Соёлын илрэх хэлбэрүүд

**ЭКОЛОГИЙН СОЁЛ**

Байгаль орчинтой зөв харьцах, хайрлан хамгаалах

**СЭТГЭЛГЭЭНИЙ СОЁЛ**

Тодорхой эмх цэгцтэй сэтгэх, асуудлыг шүүх, тунгаах

**ГОО САЙХНЫ СОЁЛ**

Өөрийгөө, орчноо сайхнаар авч явах

**ЭРХ ЗҮЙН СОЁЛ**

Бусдын эрхийг хүндэтгэх, хуулийн өмнө тэгш эрхтэй байх

**УЛС ТӨРИЙН СОЁЛ**

Иргэний оролцоо, төрд хяналт тавих

# Соёлын илрэх хэлбэрүүд



**ХАРИЛЦААНЫ СОЁЛ**

Бусдыг сонсох, үг яриандаа хяналт тавих

**ЭДИЙН ЗАСГИЙН СОЁЛ**

Бүтээгдэхүүний чанар, шударга өрсөлдөөн

**АХУЙН СОЁЛ**

Ахуйн хэрэглээ, эдийн засгаа хэмнэх

**БИЕ БЯЛДРЫН СОЁЛ**

Спортоор хичээллэх

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- *ДЭЛХИЙ НИЙТИЙН ХЭМЖЭЭНД ДАЯАРШЛЫН ҮЕД БАРИХ ҮНДСЭН БОДЛОГЫГ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ ГЭЖ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БАЙНА.*




Монгол Улс 2005 онд дэлхийн Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт нэгдэн орсон. Энэхүү хөтөлбөрт харилцан шүтэлцээтэй эх дэлхийн зүй тогтолд хүндэтгэлтэй хандах, байгалиа нөхөн сэргээх, биологийн төрөл зүйлийг хамгаалах явдлыг манай эрин үеийн эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн шалгуур, улс үндэстэн, гэр бүл, хувь хүний эрхэмлэх зүйл гэдгийг тодорхой зааж өгсөн.

# МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БОЛОН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР ХООРОНДЫН УЯЛДАА

| Монгол Улсад шууд хамааралгүй | Шууд давхардаж байгаа | Агуулгын хувьд уялдаж байгаа болон зарчим хэсэгт тусгагдсан |
|---|---|---|
| Далай тэнгисийн нөөцийг хамгаалах | Ядуурлыг устгах | Өлсгөлөнг зогсоох |
| | Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох | Эрүүл мэндийг дэмжих |
| | Тэгш бус байдлыг бууруулах | Чанартай боловсролыг дэмжих |
| | Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих | Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах |
| | Хариуцлагатай хэрэглээг дэмжих | Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх |
| | Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах | Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх |
| | Хуурай газрын эко системийг хамгаалах | Энх тайван, шудрага ёсыг цогцлоох |
| | | Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх |
| | | Жендерийн эрх тэгш байдлыг хангах |




*Судлаач Мери Месенжер Девиэс зурагтаар үзүүлдэг балмад явдлууд хүүхдүүдэд ямар нөлөө үзүүлдгийг судалжээ.*



*Цочирдох* *Цагаатгах* *Мэдрэмжгүй болох*

# 2.5. СОЁЛЫН ЭРХ ЧӨЛӨӨ ГЭЖ ЮУ ВЭ?



# СОЁЛЫН ЭРХ ЧӨЛӨӨ ГЭЖ ЮУ ВЭ?

**ЭРХ ЧӨЛӨӨ**

**ДУНДАД ЗУУН**

БУРХНААС ӨГӨГДСӨН ЗҮЙЛ
ХҮНИЙ ДОТООД СЭТГЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

**ЭНЭТХЭГ**

Хүн байгалиас хамааралтай байх явдлыг эрх чөлөөгүй байдал гэж үзэж байсан

**ТЭМЦЭЛ**

Эрх чөлөөний төлөөх тэмцлийн ялалт бүхэн тэмцэгчиддээ эрх чөлөө авчирсангүй

**ГРЕК, РОМ**

Боолчуудтай харьцуулахад эрх чөлөөтэй гэдгээрээ бахархаж байсан.

# СОЁЛЫН ЭРХ ЧӨЛӨӨ ГЭЖ ЮУ ВЭ?

**ЭРХ ЧӨЛӨӨ**

### ДУНДАД ЗУУН

БУРХНААС ӨГӨГДСӨН ЗҮЙЛ
ХҮНИЙ ДОТООД СЭТГЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

### ЭНЭТХЭГ

Хүн байгалиас хамааралтай байх явдлыг эрх чөлөөгүй байдал гэж үзэж байсан

### ТЭМЦЭЛ

Эрх чөлөөний төлөөх тэмцлийн ялалт бүхэн тэмцэгчиддээ эрх чөлөө авчирсангүй

### ГРЕК, РОМ

Боолчуудтай харьцуулахад эрх чөлөөтэй гэдгээрээ бахархаж байсан.

# СОЁЛЫН ЭРХ ЧӨЛӨӨ ГЭЖ ЮУ ВЭ?



**Жон Локк** (1632 оны 8 дугаар сарын 29-1704 оны 10 дугаар сарын 28), либерализмын эцэг гэдгээр нь өргөн мэддэг, Английн философич, эмч. Гэгээрлийн зууны хамгийн нөлөө бүхий сэтгэгчдийн нэг.

## Жон Локк

Хэнд ч байгалиас заяасан засаглах эрх, өөрөөр хэлбэл хэнд ч бусдыгаа захирах төрөлх эрх байхгүй. Эрх бол хүн бүрд хамаарах ёстой. Хүнд төрөлхөөс заяасан гурван эрх байна. Энэ нь ***амьдрах эрх, эрх чөлөөтэй байх эрх, өмчлөх эрх*** юм. Хуулийн зорилго нь хүний эрхийг устгах буюу хавчин хясах явдал биш, харин түүнийг хамгаалж өргөжүүлэх явдал мөн.

2019

# СОЁЛЫН ЭРХ ЧӨЛӨӨ ГЭЖ ЮУ ВЭ?



Дж. Кэмпбелл 1904-1987

## Дж. Кэмпбелл

Бид хараат байдлаас гарч, эрх чөлөөг оллоо гэхэд юу хийхээ мэддэг байх нь хамгийн чухал. Эрх чөлөөтэй байх эсэх нь хувь хүнээс өөрөөс нь шалтгаална.

2019

# СОЁЛЫН ЭРХ ЧӨЛӨӨ ГЭЖ ЮУ ВЭ?



Төрсөн огноо: 1900 оны гуравдугаар сарын 23
Төрсөн газар: Майны Франкфурт, Герман
Нас барсан: 1980 оны гуравдугаар сарын 18,
Нөлөөлсөн: Зигмунд Фрейд, Карл Маркс, Max Horkheimer,

## Э. Фромм

Хуурмаг эрх чөлөө нь хүнийг ганцаардуулж, хорвоо ертөнцөд итгэх юмгүй, айж хургасан нэгэн болгодог. Ялангуяа кибернетикийн хувьсгал, цөмийн зэвсэглэл гэх мэт хүний оюун ухаан, техникийн өндөр чадвар, соёлын жишиг нь нийгмийн зах чанарыг хүнлэг бус болгож байна.

Хүн бүрт олгогдсон адил тэгш боломжийг хэлнэ. Энэхүү боломжийг төрөөс, эсвэл хэн нэгэн хүнээс авч болдоггүй учраас хүний эрх жам ёсны шинжтэй юм.

## ХҮНИЙ ЭРХ






## ЭРХ ЧӨЛӨӨ

Хүн бүр бусдын эрхийг хүндлэн өөрийн үйлдлээ сонголтын үндсэн дээр хийх боломж, түүний баталгааг хэлнэ.

**Үйл ажиллагаа 2.16.** *Тохиолдол шинжлээрэй.*

1. Германд ажилд саад учруулахгүй хэмээн албан байгууллагын хаалгыг ямагт хаасан байдаг. Харин АНУ-д ажлын газрын хаалга ихэвчлэн нээлттэй байдаг. Хаалттай хаалга нь хүмүүст найрсаг бус харилцааны мэдрэмжийг үүсгэж байна гэж Германд ажиллаж буй америкчууд гомдоллох тохиолдол гардаг гэнэ.

2. Казах оюутан Б монголоор сайн ярьж чаддаггүй. Хэлний бэрхшээлээс болж ангийнхандаа шоолуулж, буруу зөрүү хэлж ярьсан зүйлээсээ болж янз бүрийн хоч авдаг. Хичээлээ сайн хийдэг ч буруу ойлгосноос болж зарим үед сул дүн авна. Энэ байдлаасаа болж өөртөө гомдох, шантрах тохиолдол гардаг гэнэ.

*Асуулт:*

*1. Тохиолдол тус бүрд гомдоллоход хүргэсэн гол асуудал нь юу байв? Ямар хүчин зүйлс нөлөөлсөн бэ?*

*2. Уг асуудлыг шийдвэрлэж болох ямар, ямар арга зам байж болох вэ? Эдгээрээс хамгийн гол арга замыг тодорхойлно уу*

# СОЁЛЫН ЭРХ ЧӨЛӨӨ ГЭЖ ЮУ ВЭ?

## Соёлын эрх чөлөө

1. Бүх хүмүүс эх хэлээрээ ярьж, өөрийн шашныг шүтэж, өөрийн соёлыг бүтээн туурвих боломжоог эдлэх эрх .
2. Хүмүүс өөрсдийгөө илэрхийлэх, өөрийн хувь чанараа хөгжүүлэх, хэн байх, хэрхэн аж төрөх вэ? Гэдгээ сонгох чадвар
3. Баталгаат боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, бусал олон төрлийн нийгмийн баталгаагаар хангагдах эрх



НҮБ-ын Хүний хөгжлийн илтгэл

# 2.6. СОЁЛЫН ОРОН ЗАЙ ГЭЖ ЮУ ВЭ?










Засаг төр нь дарангуйллын дэглэмтэй улс орнуудад мэдээллийн тоог нэмэгдүүлнэ гэдэг бол нэг талаас нь аваад үзвэл шууд **хувьсгалд** хүргэнэ гэсэн үг. Нөгөө талаас, мэдээллийн илүүдэл нь сайн юм юу ч амлахгүй. Хэтэрхий их байна гэдэг бол ерөөсөө **тэг буюу хоосон** гэсэнтэй адилхан. Өнөөдөр Интернет рүү ороод цорын ганц нэг асуултанд арван мянган нэр төрлийн ном бүхий хариу хүлээн авч байна, би тэдгээртэй яаж харьцах вэ? Ийм тохиолдолд тэр арван мянган ном ердөө шууд л тэгтэй тэнцэнэ.

Өнөөдөр бид бүхний дасал болсон “уншигч” хэмээх ойлголтын оронд мэдээллийн программуудыг “хэрэглэгч” хэмээх ойлголт нэвтэрсэн. Интернетэд “бүх юм” бий



Хүмүүсийн ном уншихад зарцуулдаг цаг бараг үгүй болсон гэхэд болно. “NOP World” компанийн гаргасан судалгаагаар дэлхийн хамгийн их ном уншдаг орноор **Энэтхэгийн иргэд** шалгарчээ. Тэд уншлагад долоо хоногт 10,7 цагийг зарцуулдаг аж. Энэ жагсаалтыг **Хятад, Тайланд, Филиппин, Египет** зэрэг орнууд үргэлжлүүлж байгаа бол АНУ уг жагсаалтын 23-рт бичигджээ. Энэ нь тус орны иргэд ном уншихад долоо хоногт 5.7 цаг зарцуулдаг гэсэн үг юм.

Манайд 1989 оны байдлаар 418 номын сан байсан бол, 2007 оны байдлаар 278 болж 33,5 хувиар буурсан үзүүлэлт гарчээ. Номын сангийн уншигчдын тоо 1989 онд 6431 байсан бол, 2012 оны байдлаар 2233 болж 65,3 хувиар буурчээ. Үүнийг мэдээллийн олон шинэ сувгууд гарч ирсэн, чөлөөт цагаа өнгөрүүлэх бусад боломж нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж байгаа ажээ.

(Эх сурвалж: Assa.mn)



Маш  дэлгэр нутаг минь
Мал сүргээр дүүрэн
Малчин олон монголчууд
Жаргал цэнгэлээр дүүрэн
Ц. Дамдинсүрэн









Байгалийн хүчин зүйлс → Амьдралын хэв маяг → аж ахуй, оромж суурьшлын шинж чанар, харилцааны хэв маяг, хоол ундны төрөл, итгэл үнэмшил, үнэлэмж

**Соёлын орон зай.**

**Соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг оюун санааны орчинг хэлнэ. Соёлын орон зай нь төрсөн нутаг биш, соёлын дурсгалт зүйлс биш, харин улс үндэстэн, хүмүүсийн хамтын мэдрэмж юм.**

Бусад соёлын нөлөөгөөр амьдралын хэв маягт шинэ шинж байдал бий болж байдаг.

Жишээ нь, хувцасны моод, техникийн дэвшил, шинэ барааны сурталчилгаа, хотын өнгө үзэмжийн өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлс соёлын орон зайн дүр төрхийг өөрчилсөөр иржээ.


1916
OLEG GOLOVNEV / SHUTTERSTOCK


1976
GRAGNON FRANCOIS / GETTYIMAGES


2016
PYMCA / GETTY IMAGES

## Кибер орон зай.

Компьютер, технологи, интернет сүлжээнд суурилсан соёлын харилцаа, нөлөөллөөр бий болж буй хамтын мэдрэмжийг кибер орон зай гэдэг.






- Соёлын даяаршлын үед интернет хэрэглээний үр дүнд мэдээллийн чөлөөтэй урсгал бий болж, хүмүүсийн сэтгэлгээ болон зан төлөвийн ижил дүрэм журмыг дэлгэрүүлэгч соёлын онцгой харилцаа, шинэ орон зай бий болж байна. Мэдээллийн технологиор тодорхойлогдож буй харилцааны энэхүү шинэ хэв маягийг **кибер орон зай** гэсэн нэр томьёогоор илэрхийлдэг.

- Жишээ нь, интернет хэрэглээ, компьютер хөгжсөний нөлөөн дор хувь хүний эрхэмнэл, хүсэл сонирхол, үнэлэмжийн чиг баримжаа, амьдралын байр суурь, сэтгэл санааны байдал болон үзэл бодол тэргүүтэн өөрчлөгдөн хувьсаж байна. Харилцааны хэлнүүд түгэн дэлгэрч байна.

## ***Даалгавар 2.10***. Мэдээлэлтэй ажиллаарай

*Ийглийн мэдээгээр (2018. 09.07) дараах мэдээллүүдийг өгөв.*

**Монголчуудын фэйсбүүк хэрэглээ**




Улсын хэмжээнд хүн амд ногдох нүүрномын /фэйсбүүк/ хуудас хэрэглэгчийн тоогоор Монгол Улс дэлхийн дунджаас 2,1 дахин, Ази тивийн улс орнуудаас 3,6 дахин их байна.

**Цахим донтолт**

/СЭМТ-д хэвтэн эмчлүүлсэн хүүхэд/

2017 он -------55 хүүхэд

2018 оны эхний 9 сар-23 хүүхэд

2018 оны эхний 9 сарын байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд цахим дарамтад өртсөн 125, цахим донтолтын 35 дуудлага бүртгэгдэж, хүүхдүүд хамгааллын үйлчилгээ авчээ.

**Асуулт:**

1.Монголчуудын фэйсбүүк хэрэглээний өнөөгийн байдал, эерэг, сөрөг талыг дүгнэн ярилцаарай


1916
OLEG GOLOVNEV / SHUTTERSTOCK
1976
GRAGNON FRANCOIS / GETTYIMAGES
2016
PYMCA / GETTY IMAGES

**Кибер орон зай.**

Компьютер, технологи, интернет сүлжээнд суурилсан соёлын харилцаа, нөлөөллөөр бий болж буй хамтын мэдрэмжийг кибер орон зай гэдэг.





- Соёлын даяаршлын үед интернет хэрэглээний үр дүнд мэдээллийн чөлөөтэй урсгал бий болж, хүмүүсийн сэтгэлгээ болон зан төлөвийн ижил дүрэм журмыг дэлгэрүүлэгч соёлын онцгой харилцаа, шинэ орон зай бий болж байна. Мэдээллийн технологиор тодорхойлогдож буй харилцааны энэхүү шинэ хэв маягийг **кибер орон зай** гэсэн нэр томьёогоор илэрхийлдэг.

- Жишээ нь, интернет хэрэглээ, компьютер хөгжсөний нөлөөн дор хувь хүний эрхэмнэл, хүсэл сонирхол, үнэлэмжийн чиг баримжаа, амьдралын байр суурь, сэтгэл санааны байдал болон үзэл бодол тэргүүтэн өөрчлөгдөн хувьсаж байна. Харилцааны хэлнүүд түгэн дэлгэрч байна.

## ***Даалгавар 2.10***. Мэдээлэлтэй ажиллаарай

*Ийглийн мэдээгээр (2018. 09.07)  дараах мэдээллүүдийг өгөв.*

**Монголчуудын фэйсбүүк хэрэглээ**




Улсын хэмжээнд хүн амд ногдох нүүрномын /фэйсбүүк/ хуудас хэрэглэгчийн тоогоор Монгол Улс дэлхийн дунджаас 2,1 дахин, Ази тивийн улс орнуудаас 3,6 дахин их байна.

**Цахим донтолт**

/СЭМТ-д хэвтэн эмчлүүлсэн хүүхэд/

2017 он -------55 хүүхэд

2018 оны эхний 9 сар-23 хүүхэд

2018 оны эхний 9 сарын байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд цахим дарамтад өртсөн 125, цахим донтолтын 35 дуудлага бүртгэгдэж, хүүхдүүд хамгааллын үйлчилгээ авчээ.

**Асуулт:**

1.Монголчуудын фэйсбүүк хэрэглээний өнөөгийн байдал, эерэг, сөрөг талыг дүгнэн ярилцаарай

# СОЁЛЫН ЦОЧИРДОЛ

Энэ ойлголтыг анх 1954 онд К. Оберг хэрэглэжээ.



Харь орны соёлд, зан үйлийн онцлогт дасан зохицох явцад гардаг бэрхшээл

Хүн өөрт дасал болоогүй харийн соёлд орох үед олон таагүй сөрөг мэдрэмж үүсдэг.

Харийн оронд очсон анхны өдрүүдэд ихэнх хүмүүс сэтгэлээр унаж, өөрийн соёл ёс заншлыг үгүйлдэг.

# СОЁЛЫН ЦОЧИРДОЛ

Энэ байдлын учир шалтгааныг ойлгож, ийм байдалд орохгүй бэлтгэлтэй байх хэрэгтэй.
Олон талын мэдлэг, түүх, соёл, харилцааны чадвар, хүлээцтэй, тэвчээр,




Соёлын цочирдлын илрэлд бухимдал, шинэ орчин нөхцөл, хоол хүнс болон хүмүүсийг хэт шүүмжлэх, гомдоллох, нойргүйдэх, уурлах




*График 2.1. Харь соёлд дасан зохицох үе шат*

A - шинэ газар таалагдаж, урам зориг эрч хүчтэй байна.

B - харь хэл, орчин, хоол хүнс зэрэг шинэ зүйлсийг хүлээн авч чадахгүйгээс бухимдал эхэлнэ. Гэрээ санах, ганцаардах гэх мэт.

C - бага багаар орчиндоо дасаж, шинэ зүйлийг хүлээн авч чаддаг болно.

D - шинэ орчинд бүрэн дасна.

E - шинэ соёлд дассан болович, эргэн тойрныхоо хүмүүстэй харилцаа тогтоож чадахгүй.

F - найз, нөхөдгүй, нийгмээс тусгаарлагдсан мэдрэмж төрнө.

G – эргэн тойрныхоо хүмүүсийг ойлгож эхэлж, хүмүүстэй харилцаа тогтоож, аливаад уян хатан хандана.